

УЛС ТӨР

**Ю.ЦЭДЭНБАЛЫН АМЬДРАЛЫН
100 ХОРМЫГ ДЭЛГЭЛЭЭ**

II нүүрт

СПОРТ

**Б.ГАНГААМАА: БИ АВИРАЛТ
ХИЙХИЙНХЭЭ ӨМНӨ ДАРААГИЙНХАА
ОРГИЛ РУУ ДАВЖ ХАРДАГУЙ**

V нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Дугаарын **60** мөр

**НӨАТ-ЫН БАРИМТЫН
“НО” ДУУСАХГҮЙ НЬ**

Б.ДАВАА

Монголд гурван сая аэтан бий. Цэцэрлэгт элсэх, тоглолт үзэх, дэлгүүрт орох, газар өмчлөх, түрээсийн орон сууцанд амьдрах гээд ер нь бүх л зүйл сугалаанд хэр аздай эсэхээ шалтгаална. Бүр мэргэжил сонгоход ч аз чухал үүрэг гүйцэтгэдгийг надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа болов уу. Энэ бүгдээс хамгийн өргөн хүрээг хамарсан сугалаа нь НӨАТ-ын сугалаа. Энэ оны нэгдүгээр сараас “сугалаачин монголчууд” ганц талх авсан ч, үнийн дүнг нь “Ebarimt.mn”-д бүртгүүлдэг болсон. Эхэндээ сугалааны тохирол 14 хоног тутамд болж, МҮОНТВ-ээр орон даяар шууд дамжуулдаг байв. Харин одоо сардаа нэг удаа болж гялайлгах болж. Бид эртнээс нааш азын сугалаанд тэр бүр найдаад байдаггүй зантай ард түмэн. Гэсэн ч, сүүлийн үед юм бүхэн сугалаагаар шийдэгдэж байгаа хойно орчноо дагалгүй яах вэ.

Үргэлжлэл нь II нүүрт

ХЭН, ЮУ ХЭЛЭВ



Д.Эрдэнэбат:
Ардчилсан нам юу хийснийг тэртээ тэргүй ард түмэн мэднэ

Ардчилсан намыг түр

даргалж байгаа УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат ээлжит бус чуулганаар юу амжуулсан талаар болон Ардчилсан намын өнгөрсөн дөрвөн жилд хэрэгжүүлсэн бодлогын талаар ярьсан байна. Тэрбээр “Ардчилсан намын үед 1.5 тэрбум ам.долларын

Чингис бондыг гаргасан. Эрх баригчид янз бүрээр л ярьж байна. Идсэн, уусан гээд л 1.5 тэрбум ам.долларыг идэж, уудаг Ардчилсан нам ч гэж хаа байхав. Харин энэ бондын мөнгө зээл хэлбэрээр үйлдвэрлэгчдэд очсон юм. Энэ хэдэн замыг холбохоос

эхлээд дулааны шугам, сүлжээг засч, сайжруулах, дулааны станцыг барих, эрчим хүчний нэмэгдүүлэх, үйлдвэр үйл ажиллагааны өргөтгөл гээд бүх тооцоолол нь ойлгомжтой, хүний нүдэнд харагдах хийсэн ажилтай.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

**АН-ЫН ҮЗХ
ХОЙШИЛЛОО**

Ардчилсан Намын Үндэсний зөвлөлдөх хорооны ээлжит хурал сонгуулийн дараахан ялагдлын шархаа аниагүй байх үед хуралдаж эхэлсэн ч төлөвлөсөн асуудлуудаа хэлэлцэж амжилгүй тарсан. Үүнээс хойш хэд хэдэн удаа ҮЗХ-ын хуралдаанаа хойшлуулаад байгаа билээ. Тодруулбал, өнгөрсөн долдугаар сарын 29-нд хуралдах ёстой байсан ч наймдугаар сарын 5-нд хуралдахаар болсон. Гэсэн хэдий ч товлосон өдрөө хуралдалгүй бас хойшлуулсан. Улмаар Ардчилсан намын ҮЗХ-ны хуралдаан өнөөдөр 14:00 цагт болох байсан ч АН-ын Гүйцэтгэх зөвлөл өчигдөр хуралдсаны эцэст уг хуралдааныг дахин хойшлуулжээ. Хуралдааныг хойшлуулснаа аравдугаар сарын 19-нд болох орон нутгийн сонгуультай холбон тайлбарласан юм. АН-ын Гүйцэтгэх зөвлөл орон нутгийн сонгуульд хүчээ дайчлан оролцох ёстой гэж үзсэн учраас ийнхүү шийдсэн аж. Тиймээс АН-ын ҮЗХ-ны хуралдааныг орон нутгийн сонгуулийн дараа хийхээр тогтсон байна.

**“ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ
ТАВТАЙ МОРИЛ**

Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.

Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг жамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО
Холбоо барих утас: 99094864

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

**Манай сонины
IV улирлын
захиалга
үргэлжилж
байна**

Улиралд **64** дугаар

**захиалгын үнэ
18000**

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН Банк				Хугалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2238.00	2253.00	ФУНТ	2917.00	3006.00	АМ.ДОЛЛАР	2237.00	2250.00
ЕВРО	2480.00	2561.00	РУБЛЬ	33.00	35.80	ЕВРО	2489.00	2565.00
ИЕН	21.64	22.19	ЮАНЬ	335.40	338.20	ИЕН	21.56	22.28
						ФУНТ	2936.00	3023.00
						РУБЛЬ	33.28	36.28
						ЮАНЬ	334.50	338.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

Ю.ЦЭДЭНБАЛЫН АМЬДРАЛЫН 100 хормыг дэлгэц



Гэрэл зургийн Г.АРГУУЖИН

Н.БАТЗАЯА

Гэрэл зураг түүх өгүүлнэ гэдэг дээ. Тэгвэл очигдөр "Хүннү молл"-д байрлах "Гамма" агентлагийн гэрэл зургийн галлерейд түүхийн нэгэн хуудас эргэв. Тодруулбал, БНМАУ-ын Төрийн тэргүүн, Ерөнхий сайд, МАХН-ын төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга асан, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар Ю.Цэдэнбалын гэрэл зургийн халсанд бууж үлдсэн амьдралын 100 хором дэлгэгдсэн юм. Энэ жил түүний мэндэлсний 100 жилийн ой тохиосон бөгөөд ойн хүрээнд уг үзэсгэлэнг гаргажээ. Үзэсгэлэнгийн танхимд

орохоос өмнө яагаад ч юм олны нүдэнд дасал болсон нөгөө л гараа даллаж инээсэн Төрийн тэргүүн, Ерөнхий сайдын дүр зураг байгаа байх гэсэн бодол толгойд байсныг нуух юун. Гэсэн ч үзэсгэлэнгийн дүр төрх огт эсрэгээрээ байв. Москвагийн их сургуульд элсэн орж буй оюутнаас эхлээд шинэ жилийн үдэшлэгт залуухан бүсгүйтэй бүжиглэх хөгжилтэй залуу, ээж, охин дүүгийн хамт гэрийнхээ гадаа инээмсэглэн суух хүү гээд түүнийг бусдын л адил эгэл жирийн хэрнээ энгүй нэгэн байсныг илэрхийлэх гэрэл зургууд утгасан юм. Тус үзэсгэлэнг СГЗ, "Гамма" агентлагийн гэрэл зурагчин С.Цацралт, МУБИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор Ч.Болдбаатар нар хамтран гаргаж байгаа аж. Энэ үеэр СГЗ, "Гамма" агентлагийн гэрэл зурагчин С.Цацралт "Ю.Цэдэнбал нам



төрийн удирдагчийг 44 жил хийсэн гэдгээрээ Монголын түүхэнд мөнхрөн үлдсэн. Тиймээс бид энэ хүнийг удирдагч гэхээс илүү бусдын адил хүн байсан юм шүү гэдгийг харуулахыг зорьсон. Манай үзэсгэлэн ямар нэгэн улс төрийн зорилго агуулаагүй. Бид үзэсгэлэнг бие дааж хийж байгаа. Төр засаг, нам, холбооны тусламж, дэмжлэг аваагүй. Би гэрэл зураг цуглуулдаг, гэрэл зурагчин хүн. Өөрийнхөө цуглуулсан зурагнаас сорчилж авсан. Ер нь 1916-1991 он хүртэлх зурагнаас сонгосон. Монголын түүхэнд Ю.Цэдэнбал, маршал Х.Чойбалсан нарын зураг маш

их байдаг. Ю.Цэдэнбалын бүх зургийг үзүүлнэ гэвэл Хүннү моллын үзэсгэлэнгийн танхим байтугай талбай хэрэгтэй болно. Хүмүүс түүнийг улс төрийн талаас сайн, муу гээд янз бүрээр ярьдаг. Тиймээс хувь хүнийхээ хувьд ямар хүн байсан юм бэ гэдгийг л үзэсгэлэнгээрээ харуулахыг зорьсон" гэсэн юм. Мөн тэрбээр уг үзэсгэлэнг гаргахын тулд хэд хэдэн хүнтэй уулзаж, судалгаа хийжээ. Түүний ажилд ихэвчлэн залуучууд тусалсан бөгөөд зарим нь Ю.Цэдэнбалын талаар мэдэхгүй байсан нь сэтгэлийг нь их эмзэгүүлсэн гэдгийг онцолж байлаа. Тиймээс залууст

хандаж энэхүү үзэсгэлэнг ирж үзээрэй хэмээн уриалсан. Энэ өдөр Ю.Цэдэнбалын амьдралын 100 хормыг сонирхохоор ирсэн хүмүүс олон байлаа. Цугларсан олны дунд инээж хөхөрсөн, гайхаж дуу алдсандаа гэрэл зургийг имтэрсэн басхүү гүн бодолд автаж зогссон нэгэн ч харагдав. Мэдээж үзэсгэлэнд ирсэн хүн бүр дотроо нэгийг бодож, сэтгэл ханасан нь тэдний харц, үйл хөдлөлөөс илэрхий. Үзэсгэлэнгийн үеэр Ю.Цэдэнбалтай гурван ч удаа уулзаж байсан гэх Алтан гадас одонт У.Заяат гуайтай таарсан юм. Тэрбээр, "Дурсамж сэргээд сайхан байна. Би Цэдэнбалгуайтай гурван удаа уулзсан. Уулзалтынхаа нэгхэн хэсгийг нь дурдвал, тухайн үеийн ЗХУ-ын тусламжтайгаар барьсан өвөл ажиллуулахад хэцүү байна гэж хэлсэн. Ю.Цэдэнбал дарга зүйтэй гэж байсан. Тийм л хүн" хэмээн бидэнд дурсамжаа хуваацсан. Үзэсгэлэнд дэлгэгдсэн гэрэл зургийн түүх болон тайлбарт МУБИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ч.Болдбаатар ажиллажээ. Тэрбээр үзэсгэлэнгийн тухай "Ю.Цэдэнбал 1916 онд мэндэлж, 1991 онд таалал төгссөн. Энэ хүртэлх хугацаанд гэрэл зургийн халсанд үлдсэн агшныг дэлгэсэн. Гэрэл зураг түүхийн үнэт сурвалж болдог. Тэр утгаараа гэрэл зураг бүрт үзэгчид өөрсдийнхөөрөө тайлбархнийг байх. Ю.Цэдэнбалыг үнэлэх үнэлэмж сайн, муу гэсэн хоёр талтай байдаг л даа. Бид энэ үзэсгэлэнгээрээ Ю.Цэдэнбалыг үнэлж, дүгнэх гэсэн юм биш. Зүгээр л хүмүүст Ю.Цэдэнбал гэж ийм хүн байсан юм шүү гэдгийг л харуулахыг зорьсон. Маш энгийн" хэмээв. Үнэхээр ч энэ үзэсгэлэн маш энгийн хэрнээ хүн бүрийн сэтгэлд хүрч байлаа. Үзэсгэлэнгийн танхимын хаалганы зүүн хэсэгт түүний амьдралын сүүлийн мөчүүдийг харуулсан зургууд тавигджээ. Сонирхвол, түүний шарилыг ОХУ-аас авчирч буй мөч, түүнийг сүүлийн замд нь үдэж байгаа үе гэрэл зурагчдын хальсанд үлдсэн нь эдүгээ бидэнд Ю.Цэдэнбал гэж нийм л амьдралыг туулж ирсэн хүн шүү гэдгийг харах боломжийг олгосон юм шиг. Энэ хэсгийг сонирхсон хүн бүрийн харц нэг л уйтгартай болж байгаа нь илэрхий байв. Харин үзэсгэлэнгийн танхимаас гарах хаалганы дэргэд түүний дулаан инээмсэглэсэн зургийг байрлуулсан нь үзэсгэлэнг сонирхсон бүр сэтгэл өөдрөг гараасай гэсэн мэт. Нэгэн цагт Монголын нэрт удирдагч явсан Ю.Цэдэнбал Монголын хойч ирээдүй болсон бидэнтэй, бидний үр хүүхэдтэй ч гэрэл зургаар дамжуулан уулзаар, өөрийгөө илэрхийлээр байх биз ээ.

MINFO logo and contact information for 'МОНГОЛЫН МЭДЭЭ' including phone numbers and addresses.

Advertisement for 'ШАР МЭДЭЭ' featuring a doctor and text about medical services and a 'Namryн ногоон өдрүүд-2016' event.

Advertisement for 'НОАТ-ын баримтын "но" дуусахгүй нь' with a '60' mör logo and text about the NOAT system.

Editorial contact information for 'МОНГОЛЫН МЭДЭЭ' including phone numbers and addresses.

Advertisement for 'Namryн ногоон өдрүүд-2016' event, featuring a photograph of a group of people and text about the event's goals and dates.

Advertisement for 'НОАТ-ын баримтын "но" дуусахгүй нь' with a '60' mör logo and text about the NOAT system.

ҮЗЭЛ БОДОЛ

ҮЗЭД БОДОЛ

...Ахмадуудыг алагчлаад байгаа учраас Хамтын тэтгэврийн тухай хуулийг Засгийн газар буцаан татаж, хүчингүй болгохоор болсон. Ингэлээ гээд бид ахмадуудаа харж үзэхээргүйгээр, ор тас орхиж байгаа юм биш. Оронд нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа 300 мянган ахмадын эрх ашгийг хамгаалсан хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ярьж байна...

ХЭН, ЮУ ХЭЛЭВ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Хүн бүрийн амьдралд бодитой мэдрэгдсэн зүйлийг зүгээр улстөржүүлээд үгүйсгэж чадах ч үгүй. Ардчилсан нам юу хийснийг тэртээ тэргүй ард түмэн мэднэ. Энэ бүхнийг Ардчилсан нам идэж, уугаад өрөнд оруулсан гэдэг зарын шинжтэй зүйл явуулаад түүнийхээ халхавчин дор ийм явууругүй зүйл хийж байгаа юм. 1.5 тэрбум ам.долларын зээлийг олон улсын захаас тухайн үед 4.5 хувийн хүүтэй авч байлаа. Гэтэл өнөөдрийн Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хариуцлагагүй мэдэгдлийн дараа энэ хүү найман хувь болж өсч, валютын ханш хүртэл саваад гадаад зах зээл дээр сөрөг савлагаа үүсгэж байна. Өнгөрсөн сонгуулиар МАН тулгал нь шуудсан. Ардчилсан нам баахан зээл аваад өөрсдөө идэж, уугаад дууссан. Өр нь ард түмний нуруун дээр бууна. Иргэн бүр 15 сая төгрөгийн өртэй. Манай нам энэ өрийг байхгүй болгоно гэдэг амлалт өгөөд сонгогдсон. Орсон айл, очсон сум бүхэндээ үүнийгээ л ярьж явсан.

Өнөөдөр бодит байдлыг эргээд харья. Энэ зээлийг ихэнх нь жижиг, дунд үйлдвэрийнхэн, экспортын үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд, уул уурхайнхан өөрсдийнхөө бизнесийг өөд нь татахын тулд авсан. Тухайн үед 4.5 хувийн хүүтэй авсан зээл тэдэнд найман хувийн хүүтэй олгогдож байсан бол өнөөдрийн эдийн засгийн энэ олон хариуцлагагүй үйл явцаас болоод 10 гараад “давхичихлаа”. Найман хувьтай байсан зээлийн эрсдэл үйлдвэр эрхлэгчдэд өнөөдөр 15-16 хувьтай. Дээрээс нь Монголбанк бодлогын хүүгээ нэмснээр бизнес эрхлэгчдийгээ асар том эрсдэл рүү чирээд оруулчихлаа. Энэ улс орны амьдралыг зөвхөн татвар төлөгч эсхүл нэг татвараар оруулсан мөнгийг зарлагдагч нарын хэмжээнд ойлгож болохгүй. Улс орны эдийн засгийн хөдөлгөгч хүч нь ажил олгогчид болон ажил эрхэлж байгаа хүмүүс. Энэ чинь зөвхөн төсвийн тухай ойлголт биш. Тиймээс ч Ардчилсан намын бодлого хатуу байсан юм” хэмээн ярьжээ.

МЭДЭЭЛЭЛ

Мах, ногооны үнийн уналт дефляцид хүргэв

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр наймдугаар сард хэрэглээний үнийн улсын индекс буюу инфляци -0.6 хувьд хүрлээ. Ингэснээр Монгол Улс Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэн 26 жилийн түүхэндээ анх удаа дефляцийг харж байна. Тэгвэл яагаад ийм нөхцөл байдал бий болсон бэ гэдэг нь анхаарал татаж байгаа юм.

Монголын эдийн засаг улирлын мөчлөгтэй. Есдүгээр сар бол хичээл, сургууль эхлэх цаг. Өөрөөр хэлбэл, малчид

хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөхийн тулд малаа зарах цаг юм. Эрэлт бага байгаа үед нийлүүлэлт ихсэхээр үнэ буурдаг нь эдийн засгийн энгийн логик. Өөрөөр хэлбэл, наймдугаар сард махны нийлүүлэлт нэмэгдсэнээр үнэ нь буурчээ. Харин махны үнийн бууралт инфляцид өндөр нөлөөтэй.

Тодруулбал, УСХ өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг өсөлтийг 329 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн дунджаар тооцдог.

Энэхүү 329 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн дотроо мах, ногоо болон бусад хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт 30 гаруй хувийн жинг эзэлдэг байна. Тэгвэл наймдугаар сард мах, ногоо болон бусад голлох хүнсний бүтээгдэхүүний үнэ буурсан нь инфляци хасах утгатай гарахад голлон нөлөөлжээ.

Нөгөөтэйгүүр эдийн засагчид Монголыг дефляциас айх хэрэггүй гэдгийг хэлж буй бөгөөд энэ удаагийн дефляци түр зуурын шинжтэй гэдгийг онцолж байгаа юм.

С.Чинзориг: Ахмадуудынхаа эрх ашгийг хамгаалсан нийтлэг хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй

УИХ-ын ээлжит бус чуулганаар Хамтын тэтгэврийн тухай хуулийг хүчингүй болгосон. Энэ үндэслэлээ Засгийн газрын сайдууд тайлбарлахдаа шагшин, сүсэг бишрэлтэй холбосон нь нийгмийг тэр чигээр нь бухимдуулсан билээ. Харин УИХ-ын гишүүн С.Чинзориг үндэслэлтэй, мэргэжлийн тайлбар хийж, нийгмийн бухимдлыг бага ч болов дарсан. Мөн тэрбээр саяхан өгсөн ярилцлагынхаа үеэр энэ талаар ярьжээ. Тэрбээр “Нийт ахмадын эрх ашгийг хамгаалсан, өгөөжтэй хууль болох нь гэсэн хүлээлттэй байсан. Гэтэл өмнөх эрх баригчид энэ хуулийг багтахдаа хэрэгжүүлэх хугацааг нь 2017 оны нэгдүгээр сарын 1-н болгон хойшлуулсан. Үүнээс гадна өнөөдрийн байдлаар хань ижлээ алдсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа бүх ахмадын эрх ашгийг энэ хуулиар зохицуулж чадахгүй байгаа юм. Харин бидний хийсэн судалгаагаар өнөөдөр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа 300 гаруй мянган ахмад байна.

Энэ хүмүүсийн эрх ашгийг Хамтын тэтгэврийн тухай хууль бүрэн хангаж чадахгүй байгаа. Нийт тэтгэвэр авч байгаа ахмадын 77 мянга нь хань ижлээ алдсан хүмүүс байгаа юм. Гэтэл өмнөх Засгийн газар Хамтын тэтгэврийн тухай хуулийг батлуулахаар санал болгож, УИХ-д оруулахдаа 2005 оноос хойш хань ижлээ алдсан ахмадуудыг Хамтын тэтгэврийн тухай хуульд хамруулна гээд заачихсан. Гэтэл 2005 оноос хойш хань ижлээ алдсан ахмадуудын тоог гаргахаар 17 орчим мянга болж байна. Тодруулбал, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа ахмадуудын дунд 77 мянган ахмад бий. Тэдгээр ахмадын эрх ашгийг бүрэн хангаж чадахгүй буюу нийт ахмадын 20 хувийг л хангасан хууль хэрэгжихээр болсон. Ахмадуудыг алагчлаад байгаа учраас Хамтын тэтгэврийн тухай хуулийг Засгийн газар буцаан татаж, хүчингүй болгохоор болсон. Ингэлээ гээд бид ахмадуудаа харж үзэхээргүйгээр, ор тас орхиж байгаа юм биш. Оронд нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа 300 мянган ахмадын эрх ашгийг хамгаалсан хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ярьж байна. Өөрөөр хэлбэл, манай намын мөрийн хөтөлбөрт ахмадуудын нийгмийн хамгааллыг сайжруулахтай холбоотойгоор Ач санах хуулийг боловсруулж, хэрэгжүүлнэ гэсэн заалт багтсан байгаа.

Мөн ахмадуудаа Монгол Улсын иргэн хүний хувьд өндөр, буянтай нас зооглож байгааг нь хүндэтгээд “Насны хишиг” гэсэн тэтгэвэр олгодог болно гэж мөрийн хөтөлбөртөө тусгасан. Тэгэхээр МАН энэ мэтээр ахмадуудынхаа эрх ашгийг хамгаалсан нийтлэг хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзээд уг хуулийг хүчингүй болгосон юм” хэмээн ярьжээ.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Ада-еёёуа аїдæїїëуї
 ìóòèàò, °òñäèèí áıòуëãıé
 áàèèèüã òàèòèàò àðàà çàèü
 öуї íуãíèèã çíèèíñèíò
 çàì ààò àðà íèíü áíòààðèüã
 ñàðíèòèòèàò öуї æууї ä
 öıðòèуу áíèíñèíò-уу.

УИХ-ын гишүүн
 С.Чинзориг

MMINFO

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

MMINFO АПП
 Тал нутгийн дөвөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

Татах: TATAK PLAY STORE, TATAK APP STORE

ХААН БАНК

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Сонгон шалгаруулалт зарласан огноо: 2016.09.14

ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЖ, СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАН ХАМТРАН АЖИЛЛАХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

ХААН Банкны орон нутгийн салбар нэгжид ашиглагдах дохиоллын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж, суурилуулах, дохиоллын системийн үйл ажиллагааг 24 цагийн турш хянаж мэдээ дамжуулах гэрээт компанийг сонгон шалгаруулах тул энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай байгууллага, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй байгууллагууд ХААН Банкны 50000045060000035 тоот дансанд 50,000 төгрөгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй тушааж, баримтыг оролцох хүсэлтийн албан бичгийн хамт Төв ХААН Банкны ресепшинд өгч, сонгон шалгаруулалтын өгөгдлийг авна уу.

Материалыг 2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цаг хүртэл Төв ХААН Банкны ресепшин хүлээн авах ба зөвхөн шалгарсан компани, аж ахуйн нэгжид бичгээр хариу мэдэгдэнэ.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж-25, ш/х-192 Улаанбаатар 14250

Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг procurement2016@khanbank.com хаягт хандаж авна уу.

Харилцагчийн мэдээллийг төв 1800-1917 | www.khanbank.com | khanbank.com/facebook | khanbank.com/twitter



Бадамгаравын ГАНГААМАА:



БИ АВИРАЛТ ХИЙХИЙНХЭЭ ӨМНӨ ДАРААГИЙНХАА ОРГИЛ РУУ ДАВЖ ХАРДАГГҮЙ

Н.ПУНЦАГБОЛД

Дэлхийн зулай Эверестийн оргилд хөл тавьсан Монголын анхны элэгтэй, Монгол Улсын Гавьяат Тамирчин, Уулын спортын Олон улсын хэлжээний мастер Бадамгаравын Гангаатаатай ярилцлаа. Тэрбээр дэлхийн долоон тивийн зургаагийнх нь ноён оргилд гарсан бөгөөд долоо дахь авиралтаа удахгүй хийх гэж байгаа юм.

-Та удахгүй Антарктидын ноён оргил ВинсонМассифт гарахаар бэлтгэж байгаа. Өмнө нь зургаан ноён оргилд гарсан. Долоо дахь дайралтын зорилгоосоо манай уншигчидтай хуваалцаач?

-Уулын спортод өндөр уулын төрлөөр хоёр том амжилтыг уулчид үзүүлдэг. Түүний нэг нь дэлхийн долоон тивийн ноён оргилд гарах байдаг. Энэ бол үнэхээр том амжилт байдаг. Тэгвэл

тэрхүү долоон том оргилын нэг нь Антарктидын ноён оргил Винсон Массифт юм. Ази, Европ, Өмнөд Хойд Америк, Африк, Австрали ба далайн орнууд, Антарктидын гэсэн долоон ноён оргил байдаг юм. Түүнээс би зургаад нь хөл тавьж, эх орныхоо далбаг мандуулсан.

Төгсгөл нь VII нүүрт

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Х.Баттулга Жүдогийн холбоог 2020 он хүртэл удирдана

Монголын жүдо бөхийн холбооны ээлжит VI их хурал МҮОХ-нд болсон билээ. Их хуралд Монголын жүдо бөхийн холбооны ерөнхийлөгч Х.Баттулга МЖБХ-ны тэргүүн дэд ерөнхийлөгч Д.Дорлингжав, нарийн бичгийн дарга М.Бөхбат Үндэсний шигшээ багийн албаны дарга Ч. Насантогтох болон дэд ерөнхийлөгч шигшээ багийн тамирчид, дасгалжуулагч оролцсон. Энэ хурлаар жүдогийнхон алдаа оноогоо яришдаж, цаашид яаж ажиллах талаараа ч хэлэлцсэн. Тэгвэл энэ хурлаар Жүдогийн холбооны Ерөнхийлөгчийг сонгох хэлэлцүүлэг боллоо. Холбооны Ерөнхийлөгч Х.Баттулга энэ оньг дуусгаад ажлаа өгөх бодолтой байгаа талаараа ярьсан учир нийм хэлэлцүүлэг өрнүүлэхэд хүргэсэн билээ. Харин Их хуралд оролцогчид түүнээс өөр Жүдогийн холбооны Ерөнхийлөгчийн төлөө өрсөлдөх өрсөлдөгч байхгүй учир 100 хувийн саналаар улируулан сонгосон юм. Ингэснээр Жүдогийн холбооны Ерөнхийлөгч Х.Баттулга 2020 он хүртэл их спортын төлөө зүтгэхээр боллоо.

Идэрчүүдийн УАШТ-ий шигшээ тоглолтууд эхэллээ

МХБХ-оос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Өсвөр, Идэрчүүдийн УАШТ"-ий шигшээ тоглолтууд энэ өдрүүдээр явагдаж байна. Хэдхэн хоногийн өмнө 11, 13 хүртэлх насны ангилалын аваргууд тодорсон бол өчигдөр 15, 17 насныханы тэмцээн эхэлсэн. Энэ жилээс эхлэн тус тэмцээн урьдчилсан шатны сонгон шалгаруулалттайгаар

явагдах болсон. Алтай, Хангай, Талын, Улаанбаатар хотын гэсэн дөрвөн бүсээс шалгарсан багууд ийнхүү шигшээ тоглолтуудыг хийж байгаа. Энэ хоёр насныханаас эхний наймд орсон багууд "Идэрчүүдийн лиг"-т оролцдог ороо очилдогтой. Өсөх ирээдүйтэй залуу тоглогчдын ширүүн өрсөлдөөн өс хоногийн турш үргэлжилж энэ сарын 22-нд аваргуудаа тодруулна.

Олимп, дэлхийн аварга Шинжи Хосокава хичээл зааж байна



Олон улсын олимпын хорооны эв санааны нэгдлийн сангийн дэмжлэгтэйгээр жүдо бөхийн дасгалжуулагчийн үндэсний семинар Улаанбаатар хотноо болж байгаа билээ. Өчигдөр эхэлсэн энэхүү семинар гурван өдөр үргэлжилж, маргааш өндөрлөнө.

Семинарыг Олон улсын жүдо бөхийн холбооны мэргэжилтэн олимп, дэлхийн аварга Шинжи Хосокава удирдаж явуулж байгаа юм. Тэрбээр өчигдөр Монголын жүдо бөхийн дасгалжуулагч нарт хөл техникийг хэрхэн сайжруулах талаар хичээл заасан юм.

Британийн пологийн баг Монголд нөхөрсөг тоглолт хийнэ

Их Британи болон Монгол улсын нөхөрсөг харилцааг бататгах polo тэмцээн маргааш Гачууртад байрлах "Хаан поло" клубт болох гэж байна. Нөхөрсөг тэмцээнд оролцох Их Британи улсын армийн поло баг Монгол Улсад хүрэлцэн иржээ. Их Британи улс Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон анхны барууны улс хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн байдаг бөгөөд хоёр улсын нөхөрсөг харилцаа, погоор холбогдсон түүхээ хүндэтгэн үздэгийн илэрхийлэл болгож ийнхүү олон улсад нэр хүндтэй армийн багаа Монголд урьж ирүүлээд байна. Энэхүү үйл явдал нь хоёр улсын батлан хамгаалах, соёл, аялал жуулчлалын харилцаанд шинэ түүхийг бүтээх ач холбогдолтойг тэмцээнийг хамтран зохион байгуулагч Их Британийн Элчин Сайдын Яамнаас онцолж байна. Поло спортын ур чадвараар түүчээлэгч багууд өмнө нь гурван ч удаа хамтарсан бэлтгэл хийж байсан бөгөөд 2015 онд Монгол Улсын Батлан Хамгаалах Яамны оролцоотойгоор Хэнтий аймгийн цэргийн баазад анхны хамтарсан бэлтгэл хийж байв. Удалгүй Монгол армийн баг Их Британи улс дахь Сандхерст Хатан Хааны Цэргийн Академид сургуулилт хийснийхээ дараа алдарт Guards Polo Club-д анхны томоохон тэмцээндээ оролцож байсан юм. Британи Монголын армийн поло тэмцээн нь олон нийтэд нээлттэй тул поло төдийгүй морин спорт сонирхогчид үзэгчдээр оролцох боломжтой.

Азийн оюутны аваргын сугалааг зарлалаа

Улаанбаатар хотод зохиногдож буй болж олон улсын тэмцээний буухиаг үргэлжүүлж, хэдхэн хоногийн дараа Азийн оюутны аварга шалгаруулах эрэгтэйчүүдийн сагсан бөмбөгийн VI тэмцээн нээлтээ хийх гэж байна. Азийн оюутны спортын холбоо /АОСХ/, Монгол Улсын БСШУСЯам, Монголын оюутны спортын холбоо (МОСХ), Монголын үндэсний сагсан бөмбөгийн холбоо (МУСБХ), Монголын сагсан бөмбөгийн холбооноос хамтран

зохион байгуулж буй тэмцээн есдүгээр сарын 18-25-нд болно. Тэмцээний сугалаа аль хэдийн явагдсан бөгөөд БНСУ, БНХАУ, Макао, Монгол, Казахстан, Тайвань, Хонконгийн багууд тэмцээнд өрсөлдөнө. Багууд хоёр хэсэгт хуваагдаж, тойргоор тоглоно. Журмын дагуу "А" хэсгийг 2014 оны тэмцээний аварга БНХАУ-ын баг, "В" хэсгийг өнгөрсөн жилийн тэмцээний мөнгөн медальт Хятадын Тайванийн баг тэргүүлж байна. Багууд

хэсэгтэй тойргоор тоглож, хэсэг тус бүрээс эхний хоёроор шалгарсан багууд нөгөө хэсгийн багуудтай зөрж тоглох бөгөөд цаашид медалийн төлөө хасагдах журмаар тэмцээн явагдах аж. Тэмцээний удирдчилсан тоглолтууд есдүгээр сарын 19-21-нд Хандгайт дахь Сагсан бөмбөгийн ордонд үргэлжилж, есдүгээр сарын 22-нд амарна. Харин хагас шигшээ болон шигшээ тоглолтууд есдүгээр сарын 23-24-нд "Буянт-Ухаа" спортын ордонд болох юм байна.

СПОРТ

Rio 2016

ПАРАЛИМПИЙН ЭРГЭН ТОЙРОНД...

Б.ДАВАА

Бразилийн Рио-де-Жанейро хотноо болж буй зуны паралимпийн XV наадам дуусахад ердөө хоёр хоног үлджээ. Энэ удаагийн наадамд дэлхийн 170 орны 4000 гаруй

тамирчид спортын 23 төрөлд 528 багц медалийн төлөө хурд хүч авьяас чадлаа сорьж байгаа юм. Манай улсаас Бээжингийн олимпын аварга Д.Баатаржав тэргүүтэй Монголын найман тамирчин Рио-2016 паралимпийн наадамд өрсөлдөж буй бөгөөд Жүдо бөхийн

эрэгтэйчүүдийн 60кг-д Болормаагийн Ууганхүү, Пауэрлифтингийн эрэгтэйчүүдийн 88 кг-д өрсөлдсөн Энхбаярын Содномпилжээ нар эх орондоо хоёр хүрэл медалийг авчраад байгаа. Спорт гэдэг өөрөө тамирчнаас асар их хичээл зүтгэл, хөдөлмөр, сэтгэлзүй, тэвчээр, басхүү

золиос шаарддаг бол паралимпийн тэмцээнд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй тамирчид дэвжээнд хэд дахин тэсвэр хатуужлыг харуулдаг билээ. Ингээд паралимпийн XV наадмын дэвжээн дэх сонин содон мэдээллийг уншигчиддаа хүргэе.

Медалийнхаа тоогоор Хятад тэргүүлж, Монгол 68-т бичигдэж байна

			🥇	🥈	🥉	TOTAL
1	CHN	CHINA	75	58	39	172
2	GBR	GREAT BRITAIN	43	24	28	95
3	UKR	UKRAINE	31	23	27	81
4	USA	UNITED STATES	26	30	24	80
68	MGL	MONGOLIA	0	0	2	2



Малайзын "GOLDEN GUYS"


аварга Мохаммад Пузи тус олимпын түүхэнд шинэ рекорд тогтоон 12.07 секунд хурдалсан бол түүний араас Хятадын тамирчин Еифэй Ян 12.20 секунд хурдан мөнгөн медаль, Бразилийн тамирчин Родриго Парьера да Силва 12.54 секунд хурдалсан амжилттайгаар хүрэл медалийг тус тус хүртсэн байна. Харин Мухаммад Зияад Золкефли бөөрөнцөг түлхэлтээр дөрвөн жилийн өмнө паралимпийн хүрэл медаль хүртэж байсан юм. Харин энэ удаа медалийнхаа өнгийн хувиргаж, 16.84 метр зайд бөөрөнцөг түлхэн алтан медаль хүртжээ. Паралимпийн түүхэн дэх бөөрөнцөг түлхэлтийн рекордыг Австралийн тамирчин Тодд Хогец эзэмшдэг байв. 2012 оны Лондонгийн паралимпийн алтан медаль авсан тэргээр 55 сантиметр түлхсэн амжилтаар рекорд тогтоож байсан удаатай. Харин энэ удаа Малайзын тамирчин түүний амжилтыг шинэчлэн тогтоосон нь энэ. Мухаммад Зияад Золкефли "Би маш олон удаа залбирсан. Бас маш сайн сургуулилт хийсэн. Гэр бүл, улс орон, малайзчуудынхаа төлөө амжилт гаргаж чадлаа. Энэ бол миний амьдралын үр дүн" гэж ярьжээ. Энэ төрөлд мөнгөн медалийг Грекийн тамирчин Димитриос Сенникидис 16.17 метрт бөөрөнцөг түлхэн хүртсэн бол Тодд Хогец хүрэл медаль хүртсэн байна.



Паралимпийн дэвжээн дэх "Халк"

Хүчтэй гэдэг утгаар нь Ираны тамирчныг ийнхүү нэрлэлээ. Паралимпийн түүхэн дэх хамгийн хүчтэй эр гэгддэг Ираны тамирчин Сиаманд Рахман тэмцээний зургаа дахь өдөр түүхэнд тэмдэглэгдэн үлдэхээр амжилт гаргалаа. Тэрбээр пауэрлифтингийн төрөлд өрсөлдөж, 310 кг-ыг өргөж, шүтэн бишрэгчдээ алмайруулсан байна. Түүний хувьд 300-аас их кг-ыг өргөсөн анхны тамирчин болсон нь энэ. Сиаманд Рахман яах аргагүй энэ өдрийн хамгийн үзүүштэй үзүүлбэрийг харуулсан тамирчин байсан хэмээн дэлхийн хэвлэлүүд шагшин магтаж байна.

Ираны шигшээгийн "үлэмж биет" буюу паралимпийн шинэ од



Бразилийн Рио де Жанейро хотноо зохион байгуулагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 15 дахь удаагийн паралимпийн наадамд оролцож буй тамирчдаас Ираны суугааволейбольншигшээбагийнтамирчин өндөр нуруугаараа эрхгүй ялгарч байна. Мортеза Мехрзадсалакжани гэгч тэрбээр 2.46 метр өндөр бөгөөд багийн гишүүд дундаа хамгийн өндөр нь. Үлэмж биет энэ тамирчин эдүгээ Ираны гол найдвар болж буй. Учир нь тэмцээний талбайд том цамхаг мэт зогсох түүнийг гарцаагүй алтан медаль авчирна хэмээн иранчууд ихээхэн найдлага тавьж байгаа ажээ. Дааврын өөрчлөлтийн улмаас яс нь хэвийн бус хөгжсөн тэрбээр эдүгээ 28 настай бөгөөд 15 дахь паралимпийн од болон гялалзаж байна.

Залуу өөрийгөө "Мехрзад" гэж дуудуулах дуртай гэнэ. Түүний хувьд Ираны хамгийн өндөр хүн төдийгүй, Риогийн паралимпийн хамгийн өндөр тамирчин юм. Ямартай ч, Ираны суугаа волейболын шигшээ эхний хоёр тоглолтод Хятад, Боснигийн багтай таарч, ялалт байгуулсан. Тэдний хувьд алтан медалийн эзэн болохын тулд Лондонгийн паралимпийн алт авсан Украины багийг хожих хүндхэн шалгууртай тулах юм. Гэхдээ 1.15 метрээс хэтрэхгүй өндөртэй тамирчдын эсрэг "Үлэмж биет"-тэй ираны шигшээд хожих боломж байгаа. Мехрзад орон нутгийн нэгэн сонинд "Би ганцаарддаг, бас сэтгэлээр унадаг байсан. Харин паралимпийн тамирчин болж, суугаа волейбол тоглож эхэлснээс хойш миний амьдрал тэр чигтээ өөрчлөгдсөн" гэж ярьжээ.

Хадам эцэг нь хүргэнтэйгээ хүрэл медалийн төлөө өрсөлджээ

Нэг улсын хоёр тамирчин нэг цагийн зайтай паралимпийн алтан медалийг дараалан хүртсэн гайхалтай тохиолдол паралимпийн түүхэнд бичигдэн үлдсэн. Тэгвэл түүнтэй яг ижил тохиолдол мөн давтагджээ. Гэхдээ гэр бүлийн хоёр буюу хадам эцэг, хүргэн хоёр хүрэл медалийн төлөө өрсөлдсөн сонирхолтой "туялан" Риогийн танхимд болж, хүргэн нь ялжээ. Тодруулбал, туялзуур сэлэмний төрлийн тэмцээнд Польшийн хоёр тамирчин хүрэл медалийн төлөө өрсөлдсөн байна. Гэхдээ энэ удаа нэг улсын хоёр тамирчин хүрлийн төлөө өрсөлдсөн нь биш, хүргэн нь хадам эцгээ ялсан нь олны анхаарлыг хамгийн их татсан аж. Хадам аавыгаа ялж хүрэл медаль хүртсэн хүргэн хүү Адриан Кастро дөрвөн жилийн өмнө өөрийн хамтрагч мөн өрсөлдөгч Г.Плутагийн охинтой гэрлэж байжээ.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН ДЭД ЗАХИРАЛ БОЛОН "МОНГОЛЫН МЭДЭЭ" ТЕЛЕВИЗИЙН ЗАХИРЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

- Нэг. Сонгон шалгаруулалт явуулах албан тушаал:**
1. МҮОНРТ-ийн Дэд захирал
 2. МҮОНРТ-ийн "Үндэсний телевиз"-ийн захирал
 3. МҮОНРТ-ийн "Монголын мэдээ" телевизийн захирал
- Хоёр. Бүрдүүлэх материал:**
- Сонгон шалгаруулалтанд оролцох тухай хүсэлт, өөрийн мэдлэг ур чадвараа илэрхийлсэн өргөдөл
 - Дэлгэрэнгүй анкет
 - Тухайн албан тушаал дээр ажиллах үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
 - Боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
 - Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
 - Урьд ажиллаж байсан байгууллагын ажил байдлын тодорхойлолт
 - Хоёр хувь цээж зураг /4x3/
- Гурав. Тавигдах шаардлага:**
- 3.1 МҮОНРТ-ийн Дэд захирал:
- Дээд боловсролтой, магистр ба түүнээс дээш зэрэгтэй, сэтгүүл зүй, эрх зүй, маркетинг, менежментийн чиглэлийн мэргэжилтэй,
 - Хэвлэл мэдээллийн байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх, радио телевизийн онцлогийн талаар мэдлэгтэй,

- Улс төрийн намын гишүүн бус, гишүүн байсан бол түүнээсээ түдгэлзсэн эсвэл татгалзсаныг гэрчилсэн баримт бичигтэй байх
 - Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн үзэл санааг эрхэмлэдэг байх,
 - Хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах, хариуцлага хүлээх, болон харилцааны өндөр ур чадвартай, стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх чадвартай байх,
 - Компьютерийн хэрэглээний программууд дээр ажилладаг, англи болон бусад НҮБ-ын түүгээмэл хэлний өндөр мэдлэгтэй байх
- 3.2 МҮОНРТ-ийн "Үндэсний телевиз"-ийн захирал
- Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй, сэтгүүл зүй, эрх зүйн чиглэлийн мэргэжилтэй,
 - Радио, телевизийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх
 - Улс төрийн намын гишүүн бус, гишүүн байсан бол түүнээсээ түдгэлзсэн эсвэл татгалзсаныг гэрчилсэн баримт бичигтэй байх
 - Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн үзэл санааг эрхэмлэдэг байх,
 - Хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах, хариуцлага хүлээх, болон харилцааны өндөр ур чадвартай, стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөлт хийх,

- хэрэгжүүлэх чадвартай байх,
 - Компьютерийн хэрэглээний программууд дээр ажилладаг, англи болон бусад НҮБ-ын түүгээмэл хэлний өндөр мэдлэгтэй байх
- 3.3 МҮОНРТ-ийн "Монголын Мэдээ" телевизийн захирал
- Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй, сэтгүүл зүй, эрх зүйн чиглэлийн мэргэжил-тэй,
 - Радио, телевизийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх
 - Улс төрийн намын гишүүн бус, гишүүн байсан бол түүнээсээ түдгэлзсэн эсвэл татгалзсаныг гэрчилсэн баримт бичигтэй байх
 - Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн үзэл санааг эрхэмлэдэг байх,
 - Хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах, хариуцлага хүлээх, болон харилцааны өндөр ур чадвартай, стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх чадвартай байх,
 - Компьютерийн хэрэглээний программууд дээр ажилладаг, англи болон бусад НҮБ-ын түүгээмэл хэлний өндөр мэдлэгтэй байх
- Сонгон шалгаруулалтад оролцох ирээд дээрх материалуудыг бүрдүүлэн битүүлжисэн дугуйд хийж, доорхи хаягаар 2016 оны 9 дүгээр сарын 21-ний 17:00 цагаас өмнө ирж бүртгүүлнэ үү.*

Хаяг: УБ хот, Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам - 3, МҮОНРТ-ийн байр
МҮОНРТ-ийн Сонгон шалгаруулалтын комисс
Утас: 11325802

СПОРТ



Бадамгаравын ГАНГААМАА:

БИ АВИРАЛТ ХИЙХИЙНХЭЭ ӨМНӨ ДАРААГИЙНХАА ОРГИЛ РУУ ДАВЖ ХАРДАГГҮЙ

Төгсгөл.
Түрүүч нь V нүүрт

Одоо долоо дахь оргилдоо оролдлого хийхээр бэлтгэж байна. Энэ нь миний ч гэлтгүй Монголчуудын хувьд ач холбогдолтой. Өнөөдөр дэлхийн долоон тивийн ноён оргилд гарсан хүмүүсийн нэр / статистик / дунд Монгол гэсэн нэр байхгүй байгаа. Тийм болохоор тэр жагсаалтад Монгол гэдэг нэрийг бичүүлчихвэл зорилго биелэх гээд байна. Иймээс Винсон руу хийх авиралт миний ч, монголчуудын ч хувьд ач холбогдолтой юм.

-Авиралт хийхэд хэр хэцүү бол. Та судалж байгаа байх?

Дэлхий дээр амархан авираад гарчих уул гэж байхгүй шүү дээ. Ноён оргил болгон өөр өөрийн онцлогтой, цаг агаартай, замтай байдаг. Тийм болохоор энэ уул мэдээж амар биш. Далайн түвшнээс дээш 4897 метр өндөр. Эверестийн оргилтой харьцуулахад намхан юм шиг хүмүүст санагдаж байж болох. Гэвч энэ уул чинь өөрийн гэсэн араншинтай, цаг агаартай. Цаг агаарын хувьд өмнөд туйлд байгаа болохоор маш хүйтэн. Салхи, шуурга ихтэй байдаг гэсэн мэдээлэл авсан. Ууландаа -30, 40 хэм хүрч хүйтэрдэг гэсэн. Нөгөө талаар, маш хол зам туулж байж авирах ууландаа хүрнэ. Онгоцоор маш олон нислэг дамжина. Харин Антарктид руу уулчид нэгдсэн журмаар захиалгын онгоцоор явж хүрнэ. Энэ бүхнийг нийлүүлээд тооцвол маш үнэтэй авиралт болж байгаа. Өртөг ихтэй юм.

-Авиралт хийхдээ бусад орны уулчидтай хамт явна биз дээ. Ямар орны уулчидтай хамт гарах вэ?

Одоогийн байдлаар авиралт хийх уулчдын мэдээлэл гараагүй байна. Ер нь ууланд авирах улирал гэж байдаг. Тэгвэл Антарктид тивийн ноён оргил Винсон Массифт гарах хамгийн тохиромжтой хугацаа нь арваннэгдүгээр сарын сүүлээс нэгдүгээр сарын дунд хүртэл. Тэгэхээр авиралт арваннэгдүгээр сарын сүүлээр хаанахын ямар уулчин явах жагсаалт гарах байх. Авиралт эхлэхээс сарын өмнө тодорхой болох болов уу. Мэдээж олон орны уулчид хамт явах нь тодорхой.

-Аялалын зардалд 42 мянган ам.доллар хэрэгтэй гэсэн. Тиймээс та хандив цуглуулахаар хүмүүст хандаад байгаа. Одоогоор тусалж дэмжиж байгаа хүмүүс хэр байна?

42 мянган ам.доллар гэдэг бол Чили улсаас Антарктид ороод, ууландаа авираад эргэх л зардал. Тэгэхээр Чили ортол нисэх зардал. Хоол унд, буудал гээд зардал нэмэгдэнэ. Ерөнхийдөө 50 орчим мянган ам.долларын зардал гарах байх. Одоогоор хандивын үйл ажиллагаа дөнгөж л эхэлж байна. Миний хувьд хугацаа алдаж байгаа. Гэхдээ монголчууд маань жаахан ч гэсэн дэмжээсэй гэж бодож л нийтэд зарласан. Яагаад гэвэл энэ их мөнгийг би ганцаараа босгож чадахгүй, хэцүү. Нийтэд зарласнаас хойш хүмүүс дэмжиж байгаа. Одоогоор 400-аад хүнээс хандив ирсэн. 10, 20 мянгаас эхлээд чадлынхаа хэрээр хандив өргөж байна аа. Цаашид ч олон хүмүүс дэмжих байх, тийм хандлага ажиглагдсан. Яахав, цуглуулах мөнгө нь их болохоор цугларах гэж удах байх. Гэвч эх орныхоо төлөө, Монголын төлөө гэсэн сэтгэлээр дэмжиж байгаад үнэхээр их баяртай байна. Би цаашлаад бизнесийн байгууллагууд руу хандана, хүмүүстэй уулзана. Уг нь авиралт эхлэхээс 120 хоногийн өмнө урьдчилгаа гэж 5000 ам.доллар явуулах ёстой байсан. Гэвч энэ хугацаа нь өнгөрчихсөн. Одоо 60 хоногийн өмнө урьдчилгаа мөнгийнхөө 50 хувийг. 30 хоногийн өмнө бүрэн төлнө гэсэн төлөвлөгөөтэй л явж байна. Энэ авиралтыг зохион байгуулагчид нь Оросууд. Тийм болохоор урьдчилгаа өгөх хугацаандаа уян хатан хандаж өгөөч ээ гэсэн хүсэлт тавьчихаад л зүтгэж байна. Энэ хугацаанд зардлаа олно доо. Одоо надад маш олон хүн тусалж байгаа. Хандив өргөсөн тэр бүх хүмүүстэй

баярлалаа гэж хэлье. Мөн уншигчид, Монголынхоо ард түмэнд хандаад намайг дэмжээрэй гэж хүсэх байна.

-Ууланд авирах бол нэг талаар спорт. Төрөөс спортод тодорхой хэмжээнд мөнгө зарцуулдаг. Тийм болохоор та төр засгийнханд хандаад үзвэл яасан юм?

Би бүхий л арга замыг хайна, хандаж болох бүхэндээ хандана гэж бодож байгаа. Яагаад төр засгаас тусалж болохгүй гэж. Болно шүү дээ. Бид Монголдоо л тэр, энэ гэж ярьдаг болохоос эх орноосоо гарахаар ганцхан улсын нэр гардаг. Уулчид гэхэд "Манай багт нэг Монгол яваа" гэж ярьдаг. Монгол чадсан уу, чадаагүй юу гэдэг. Түүнээс биш Гангаамаа чадсан уу, чадаагүй юу гэжгүй. Тийм болохоор монголчууд, Монголын төр засаг маань дэмжлэг үзүүлж ирсэн цаашид үзүүлэх ч байх гэж бодож байна.

-Дэлхийн долоон тивийн ноён оргил дээр гараад, амжилт гаргачихвал шагнаж урамшуулдаг систем дэлхийд байдаг юм болов уу?

Тэрийг сайн мэдэхгүй байна. Шагнал байдаг уу гэдгийг судлаагүй. Бодоо ч үгүй. Ямар ч байсан рекорд амжилтад бүртгэнэ. Өнөөдөр Гиннесийн номонд оруулна гээд л янз бүрийн

амжилтуудыг бүртгэж авдаг биз дээ. Түүнтэй адил долоон оргилд гарсан хүмүүсийн жагсаалтыг гаргачихсан байдаг. Хэрвээ би амжилтыг гаргаж чадвал тэр түүхэн хүмүүсийн нэг боллоо л гэсэн үг. Одоогоор дэлхийн долоон тивийн ноён оргилд гарч чадсан 345 эрэгтэй, 71 эмэгтэй уулчин байна. Мөн Австрали ба Далайн орнуудын хоёр ноён оргил болох Карстенпирамид, Костюшкод гарч, нийтдээ найман оргилд хөл тавьсан 148 хүн байгаа. Дэлхийн долоон тивийн ноён оргилд гарч, "The seven summits"-ийг долоогоор хийсэн эсвэл наймаар хийсэн гэсэн хоёр амжилт байдаг. Тэгэхээр би наймаар хийхээр зорьж байна даа. Дэлхийн долоон тэрбум хүнээс энэ рекордыг хийсэн ердөө 148 хүн байна гээд бод доо. Хятадаас гэхэд долоон оргилд гарсан гурван л хүн байгаа. Оросоос 12 байдаг. Энэ улсууд хэчнээн хүн амтай их гүрнүүд билээ. Гэтэл ийм цөөхөн уулчин тэр амжилтад хүрч. Дэлхийд бол нийтдээ 416 хүн дэлхийн долоон оргилын амжилтыг хийжээ.

-Та дэлхийн долоо тивийн ноён оргилуудын зургаад нь гараад үзчихсэн хүн. Тэр дундаас хамгийн их сэтгэл хөдөлгөсөн, "Би чадлаа" гэж өөрөөрөө бахархсан мөчөө дурсаач гэвэл?

Мэдээж дэлхийн зулай дээр гарахад "Би чадлаа" гэж өөртөө хэлж, огшиж байсан. Мөн тив тивийн оргил болгон дээр гарахдаа ч "Би гарч чадлаа" гэж баярладаг. Уулчин хүн оргил дээр гараад баярлаж, хашгирдаггүй юм шиг байна билээ. Би бол "Чадлаа шүү" гэж боддог. Их баярлавал нулимс гардаг. Зургаа, долоон оргилд гарахдаа би бүгдэд нь үнэхээр баярлаж, нэг даваа давлаа гэж боддог байсан. Би зургаа давчихаад байна. Одоо долоо дахь даваа л үлдээд байна даа.

-Долоо дахь оргил дээрээ амжилттай гараад, уулчин хүний хүссэн амжилтыг үзүүлээд ирсний дараа яах бол. Та тэгж бодож үзсэн үү?

Одоохондоо долоо дахь оргил дээрээ гараагүй байгаа болохоор чухам яахыг хэлж мэдэхгүй байна. Гэхдээ би энэ оргил дээр амжилттай гарчихаад ирвэл том амьсгаа авах байх. Ямар ч байсан зорьсон нэг амжилтаа хүрлээ шүү гээд л том амьсгаа авна даа. Түүний дараа боллоо гэж бодох уу, яах бол гэдгийг явж ирээд л хэлье.

-Тэгвэл үүний дараагийн зорилго гэвэл?

Би авиралт хийхийнхээ өмнө дараагийнхаа оргил руу давж хардаггүй. Өнгөрсөн нэгдүгээр сард Өмнөд Америк тивийн ноён

оргил Аконкагуад гарсан шүү дээ. Оргил руу авиралт хийх гээд бааз дээр байрлаж байтал Оросын хоёр уулчин ирээд "Гангаа, чиний дараагийн авиралт чинь Винсон юм байна. Тэгээд чи долоон оргилоо дуусгачих юм байна" гэж хэлж байсан. Тэгэхээр нь би "Үгүй ээ, би энэ оргилд гараагүй байна" гэж хэлсэн. Гэтэл "Чи одоо гарчихна шүү дээ" гэж байлаа. Тэр үед "Энэ том ууланд гараагүй байж би хамаагүй хэлж чадахгүй байна. Амжилттай авирчихаад дараагийнхаа ярина" гэж хэлж байлаа. Яг л түүнтэй адилхан одоогийн зорьсон зорилгодоо хүрчихээд дараагийнхаа ярина даа. Винсонд гарчихаад ирснийхээ дараа өөр зорилго тавих байх. Одоохондоо би зодог тайлах арай болоогүй байна.

-Энэ таны сүсэг бишрэлтэй холбоотой юу?

Мэдээж сүсэг байгаа. Гэхдээ нэг хувь. 99 хувь нь хүндлэл. Өмнө чинь маш том оргил байж байхад түүнийг даваад, цаадахыг нь ярина гэдэг бол дэндүү хүндлэлгүй хэрэг болно. Би өмнөө дунхийж байгаа тэр том хайрханы оргилд гарч чадах ч юм бил үү, хэн мэдлээ. Тэр хайрхан намайг хүлээж авахгүй ч байх юм бил үү. Тийм байхад давж ярина гэхээр зүрх хүрэхгүй байна. Түүнээс биш өөртөө итгэлгүй байгаа юм биш шүү.



ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ





MMINFO АПП
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATA PLAY STORE TATA APP STORE

СПОРТ

РОНАЛДОГИЙН

ОЛОН РЕКОРД
ДАГУУЛСАН НЭГ ГООЛ

Н.ПУНЦАГБОЛД

Энэ цаг үеийн хамгийн шилдэг хөлбөмбөгчид болох Роналдо, Месси нарын оруулсан гоол болгон нь араасаа ямар нэг рекорд амжилт дагуулж байгаа билээ. Мягмар гарагийн шөнө болсон "Барселона" болон "Селтик" клубын тоглолтод Месси гурван гоол оруулж, нэгэн том рекордыг тогтоосон. Тэгвэл лхагва гарагийн шөнө "Реал Мадрид" клуб талбайдаа Португалын "Спортинг" клубыг хүлээж авч, 2:1-ээр буулгаж авсан. Энэ тоглолтын 89 дэх минутад Роналдо хаалганаас 25 метрийн зайнаас чөлөөт цохилтоор гоол оруулж, тооны харьцааг тэнцүүлсэн. Тэгвэл түүний энэхүү гоол араасаа олон рекордыг дагуулж байгаа юм. Тэрбээр энэ удаагийн тоглолтод гоолдсоноор Аваргуудын

лигт хамгийн олон удаа чөлөөт цохилтоор гоол оруулсан тоглогч боллоо. Роналдо чөлөөт цохилтоос 12 гоол оруулж, энэ рекордыг тогтоож байгаа юм. Түүнээс өмнө алдарт Алессандро Дель Пьеро Аваргуудын лигт чөлөөт цохилтоос 11 гоол оруулж, дээд амжилтыг нь эзэмшдэг байсан. Мөн чөлөөт цохилтын мастер гэгдэж байсан Жуниньо чөлөөт цохилтоос 10 гоол оруулж байж. Мөн Роналдо Аваргуудын лигт гоолдсоноор хэсгийн шатанд 50 гоол оруулсан анхны хөлбөмбөгч боллоо. Харин Аваргуудын лигт оруулсан нийт гоолынх нь тоо 94 боллоо. Ингэснээр бүх цаг үеийн мэргэн буучийн жагсаалтыг ганцаар тасархай тэргүүлж байгаа юм. Дээрээс нь Роналдо лхагва гарагийн шөнө замналынхаа 550 дахь гоолыг орууллаа. Тэрбээр "Спортинг"-ийн төлөө тав, "Манчестер Юнайтед"-ын төлөө 118, Португалын шигшсэн төлөө 61 гоол оруулсан юм. Харин "Реал"-ын төлөө 366 гоол оруулсан аварга амжилтыг үзүүлээд байна.

Аваргуудын лигт "гоолын бороо" орж байна

Европын хамгийн нэр хүндтэй тэмцээн болох Аваргуудын лигийн 2016-2017 оны улирал эхэллээ. Аваргуудын лигийн 32 баг, найман хэсэгт хуваагдаж, өрсөлдөж байгаа. Тэгвэл эхний тойргийн 16 тоглолт өнгөрсөн мягмар, лхагва гарагийн шөнө боллоо. Жил бүрийн Аваргуудын лиг онц сонирхолтой болдог. Өнгөрсөн жил Испаниас таван баг орсон нь шинэлэг байлаа. Тэгвэл энэ улиралд Английн багууд, тэр дундаа "Манчестер Сити"-гээс хөлбөмбөг сонирхогчид амжилт хүлээж байна. Мөн "Реал" Аваргаа хамгаалж чадах уу гэдэг асуулт ч гарч ирж байгаа юм. Гэхдээ эхний тойрогт багууд "гоолын бороо" оруулж байгаа нь нээлтийн хамгийн том бэлэг байлаа.

Тухайлбал, Испанийн алдарт "Барселона" клуб талбайдаа Шотландын "Селтик"-ийг 7:0-ээр буулгаж авсан. Энэ тоглолтод Месси хет-трик хийж, Суарес хоёрыг оруулсан бол Неймар, Иньеста нэг нэгийг нэмэрлэжээ. Мөн Германы "Байерн Мюнхэн" клуб Оросын "Ростов"-ыг 5:0-ээр хожсон. Германы өөр нэг баг болох "Боруссия Дортмунд" эхний тойрогт Польшийн "Легия" клубыг 6:0-ээр бутниргэлээ. Харин Пепээр удирдуулсан "Манчестер Сити" тийм ч муутгүй

өрсөлдөгч болох "Боруссия Мюнхэнгладбах"-ыг 4:0-ээр буулгаж авсан юм. Энэ тоглолтод "Сити"-гийн довтлогч Агуэро хет-трик хийлээ. Ийнхүү нээлтийн тоглолтод хоёр ч тоглогч хет-трик толилуулаад амжлаа.

Тоглолтын үр дүн

Байерн 5-0 Росов
ПСВ 0-1 Атлетико
ПСЖ 1-1 Арсенал
Базель 1-1 Лудогорет
Динамо Киев 1-2 Наполи
Бенфика 1-1 Бешикташ
Барселона 7-0 Селтик
Байер Леверкузен 2-2 ЦСКА
Брюге 0-3 Лестер
Манчестер Сити 4-0 Боруссия Мюнхэнгладбах
Тоттенхэм 1-2 Монако
Порто 1-1 Копенгаген
Реал Мадрид 2-1 Спортинг
Лион 3-0 Динамо Загреб
Легия 0-6 Боруссия Дортмунд
Ювентус 0-0 Севилья

Касильяс 18 дахь улиралдаа...

Португалын "Порто" клубын хаалгыг манаж байгаа домогт хаалгач Икер Касильяс өнгөрсөн лхагва гарагийн шөнө "Копенгаген"-ы эсрэг талбайд гарсан билээ. Ингэснээр өдгөө 35 настай Испани хаалгач 18 дахь улиралдаа Аваргуудын лигт оролцож байгаа нь энэ юм. Энэ үзүүлэлтээрээ тэрбээр "Манчестер Юнайтед" клубын домогт хагас хамгаалагч Пол Скоулзын амжилтыг давж гарлаа. Пол 17 улирал Аваргуудын лигт тоглосон юм. Харин Касильясаас олон улирал Аваргуудын лигийн тоглолтод оролцсон нэг тоглогч байгаа нь "Манчестер Юнайтед"-ын алдарт хөлбөмбөгчин Райн Гигтз юм. Тэрбээр 19 улирал Аваргуудын лигт тоглож байжээ. Касильяс Аваргуудын лигт тоглосон 16 улиралдаа Испанийн алдарт "Реал Мадрид" клубын хаалгач байсан. Энэ хугацаанд гурван удаа Аваргуудын лигт түрүүлж байсан юм.



"Тоттенхэм" хамгийн олон үзэгч цуглуулж, рекорд тогтоолоо

Аваргуудын лигийн хэсгийн Е хэсэгт багтсан Английн "Тоттенхэм" талбайдаа Францийн "Монако" багийг хүлээж авч тоглосон. Тэгвэл энэхүү тоглолтыг үзэхээр алдарт "Уэмбли"-д 85011 үзэгч цугласан нь Английн багуудын түүхэн дэх хамгийн олон үзэгчтэй тоглолт боллоо. 1934 онд Английн цомд "Манчестер Сити" болон "Сток"-ийн тоглолтыг стадионд 84467 үзэгч цугласан нь Английн багуудын хамгийн олон үзэгчтэй тоглолт гэгдсээр өдийг хүрсэн юм. Харин Английн премьер лигийн хувьд хамгийн олон үзэгчтэй нь 1948 оны "Манчестер Юнайтед"-ын талбайд болсон 83260 үзэгчтэй тоглолт ажээ.

2016.8.26

Гарах хуу

16.09.30

НЭГ ӨДРИЙН
ЛАЙСАН

Аадар багын анд Шэнгэлийнхээ дуудлагаар Дархан хотыг зорино. Гэвч тэнд Пантуг гэх түүний ооригчтай нэгэн эцгийнх нь остонтой хуйвалдан урхи бэлдсэн байв. Аадарын эцэг хазгар Чука Мандалнарт эртний тооцоо байсныг Пантуг өөрт ашигтайгаар эргүүлж найзыгаа золиослож орхино. Пантугын багсаар хайртай бүсгүй дөнгөж мэндэлсэн бяцхан охиноосоо хагацсан Аадар ч бас ор сураггүй алга болно. Зургаан жилийн дараа гэнэт гарч ирсэн Аадар чухам юу хийж хэрхэх бол? Тэр амьдралаа эргүүлэн авч чадах болов уу?

Еврейн нолоотойг бүлээ гаралтай Бен-Хур-аас ромын ниргэн хамгийн сайн найз нь урваж боол болгоно. Оргож эх орондоо ирээд өшөөгөө авна.

Хөмрөх сүүлийн 15 жил 23 ажлаас халагджээ. Уул нь тэр цахилгааны инженер болох хүсэлтэй ч хувь тавилан тэрнийг хааш нь ч хамаагүй аваад шидчихдэг гэхэд болно. Сүүлийн удаа тэр ажлаасаа халагдсанаа эхнэртээ хэлсэнгүй тас нуужээ..